



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ажлын хэсэгт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Өргөдлийн байнгын хорооны 2014 оны 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн байгууллагуудын иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх болон захиргааны үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар холбогдох хуулийн төсөл боловсруулах, мэдээллийн нэгдсэн систем, сан бий болгох, техник технологийн нийтлэг шийдэл, стандарт нэвтрүүлэхтэй холбогдсон судалгааг хийж, санал дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Н.Лүндээжанцанг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярвааг нэмсүгэй.

2.Өргөдлийн байнгын хорооны 2014 оны 10 дугаар тогтоолоор баталсан Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх иргэдийн өргөдлийг Байнгын хорооны хэлэлцүүлэгт бэлтгэх, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазарыг чөлөөлж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын орлогч дарга Э.Анар, Нийслэлийн боловсролын газрын өргөдөл, гомдол, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн Ш.Болор-Эрдэнэ нарыг нэмсүгэй.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.БААСАНХҮҮ